

**“ОРХОНДАЛАЙ”
ХУВЬЦААТ КОМПАНИЙ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны 3-р сарын 17-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуудах тухай

Компаний тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор батласан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 4-р сарын 30-ны өдрийн 13:00 цагт Монгол улс, Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай дахь компанийн байранд хуралдуулахаар тогтоосугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэхээр тогтоосугай.

- Орхондалай ХК-ий 2025 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэх;
- Орхондалай ХК-ий 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлан, дүгнэлтийг хэлэлцэх;
- Ногдол ашиг тараахгүй байх тухай төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол танилцуулах;
- Цаг агаарын эрсдэлтэй байдлаас шалтгаалан сүүлийн жилүүдэд ургац алдсан тухай хэлэлцэх;

3. Санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 4-р сарын 07-ны өдрөөр тогтоосугай.

4. Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх өдрийг 2026 оны 3-р сарын 23-ны өдрөөр тогтоосугай.

5. Хуралд бэлтгэх, зохион байгуулах, тооллогын ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар, хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар, хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус “Хурлын дэг”-ийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

6. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын тов, байршил, хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, бүртгэлийн өдөр, хурал зохион байгуулах комиссын талаарх мэдээлэл бүхий зарыг 2026 оны 03-р

сарын 18-ны өдрийн дотор Монголын хөрөнгийн бирж ХК-ийн цахим хуудсанд байршуулсугай.

7. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Нямбаяр)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА: Б. Баярхүү Б.БАЯРХҮҮ



Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны
03 дугаар сарын 17ны өдрийн 02 дугаар
тогтоолын нэг дүгээр хавсралт



**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛД БЭЛТГЭХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Хуралд бэлтгэх, зохион байгуулах, тооллогын ажлын хэсэг:

- Дарга: Б.Нямбаяр /Гүйцэтгэх захирал/
- Гишүүн: Г.Нарантуяа /Менежер/

_____оОо_____

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны
03 дугаар сарын 17ны өдрийн 02 дугаар
тогтоолын хоёр дугаар хавсралт



**ОРХОНДАЛАЙ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР
ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ ХОЛБОГДОХ ТАНИЛЦАЖ
БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

1. Орхондалай ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны тайлан
2. Орхондалай ХК-ийн 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт

_____оОо_____

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны
03 дугаар сарын 17 ны өдрийн 02 дугаар
тогтоолын гурав дугаар хавсралт



ОРХОНДАЛАЙ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

Д/д	Хурлын дэг	Хугацаа, цаг минут
1.	Хурлын ирц бүртгэх	12:00-13:00 цагт
2.	Хурлын ирц мэдээлэх	5 минут
3.	Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргыг сонгох	5 минут
4.	Хурлын дарга хурлын ажиллагааг нээж хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулах	10 минут
5.	Хэлэлцэх асуудлыг дарааллын дагуу танилцууж хэлэлцэх	Асуудал тус бүрээр 30 хүртэл минут
6.	Хуралд оролцогсдын асуулт хариулт	Хүн тус бүрээр 3 минут
7.	Хуралд оролцогсдын санал дүгнэлт	Хүн тус бүрээр 3 минут
8.	Завсарлага	20 минут
9.	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах	5 минут
10.	Хурлаас гарах шийдвэрийн төслийг танилцуулж, батлуулах	Асуудал тус бүрээр 15 хүртэл минут
11.	Хурлын ажиллагааг хаах	5 минут

оОо